



## Монголын Мянганы Сорилтын Сан

### Санхүүгийн луйвар болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө

2020.05.28

Монгол Улсын Засгийн газар нь Компакт гэрээний санхүүжилтийг зарцуулахдаа аливаа авлига эсхүл санхүүгийн луйварын шинжтэй үйлдэл, эс үйлдлээс ангид байлгах үүргийг хүлээдэг. Энэ хүрээнд Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС) болон Мянганы сорилтын корпорац (МСК)-аас хамтран Санхүүгийн луйвар болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, МСК-аар батлуулаад байна.

#### **Төлөвлөгөөг боловсруулсан аргачлал**

- 2019 оны 11 дүгээр сард Монголын МСС-гийн нийт ажилтнуудад санхүүгийн луйвар болон авлигаас урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх асуудлаар 4 өдрийн сургалт зохион байгуулсан.
- 2020 оны 1-4 дүгээр сард Санхүүгийн луйвар болон авлигын эрсдэлийн үнэлгээний матриксыг Монголын МСС болон МСК-ын баг хамтран хийж гүйцэтгэв.
- Эрсдэлийн үнэлгээний матрикс дээр үндэслэн Санхүүгийн луйвар болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулав.

#### **Санхүүгийн луйвар, авлигын эрсдэл**

Эрсдэлийн үнэлгээгээр Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацаанд гарч болзошгүй гэж үзсэн нийт 47 эрсдэлийг тодорхойлсноос хамгийн өндөр магадлалтай болон Компактыг амжилттай хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болох нийт 7 эрсдэлийг Санхүүгийн луйвар болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тухайн эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулав.

**Эрсдэлийн матриксын дүн**

<b>Гарч болох магадлал</b>	<b>Өндөр</b>	2	5
	<b>Дунд</b>	3	7
	<b>Бага</b>	7	16
		<b>Бага</b>	<b>Дунд</b>
			<b>Их</b>

**Үр нөлөө**

Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн дугаар	Эрсдэл	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Хэрэгжүүлэх хугацаа	Нэмэлт зардал	Хариуцах ажилтан
Өндөр	2.2.	Мэдээллийн аюулгүй байдал	Мэдээллийн нууцлалын журмыг боловсруулж, нууцлалын зэргээс хамааран тухайн нууц мэдээлэл тус бүрээр танилцах	2020 оны 2 дугаар улирал	Нэмэлт зардал шаардлагагүй	Гэрээний менежер, Хуулийн ерөнхий зөвлөх
Өндөр	8.6.					

			ажилтнуудын жагсаалтыг батлуулах. Журмын талаар нийт ажилтнууд болон гэрээт ажилтнуудад сургалт зохион байгуулна.			
Өндөр	2.4.	Компактын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн үйл ажиллагааны явцад шаардлага хангахгүй ажил, үйлчилгээ, бараа, материал эсхүл тайлан, судалгааг хүлээн авах	<ul style="list-style-type: none"> <li>• Монголын МСС-тай гэрээ байгуулан, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд МСК-ын Санхүүгийн луйвар болон авлигын эсрэг журмыг танилцуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</li> <li>• Төсөл хэрэгжүүлж байгаа талбайд авлигын эсрэг мэдэгдэл байршуулж, тухайн талбайд ажил гүйцэтгэгчид болон олон нийт сэжигтэй тохиолдлын талаар мэдээлэх хаяг, бусад мэдээллийг ил байршуулна;</li> <li>• МСК-аас техникийн зөвлөхөөрөө дамжуулан гэнэтийн шалгалт хийнэ;</li> <li>• Төлбөрийн баримт, гүйлгээнд хуваарьт бус аудит хийж, МСК болон түүний инженерийн багаас хуваарьт болон гэнэтийн шалгалт хийнэ.;</li> <li>• Монголын МСС-гаас ажлын явц, чанарт тогтмол, мэргэжлийн хяналт тавина.</li> </ul>	Төслийн хугацаанд	Тухайн үйл ажиллагаанаас хамаарна	Гэрээний менежер, Хуулийн ерөнхий зөвлөх
Өндөр	10.1.					

Өндөр	1.4.	Нийтийн албан тушаалтан аливаа тусгай зөвшөөрөл эсхүл бусад зөвшөөрөл олгохдоо эрх мэдлээ хэтрүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Компакт гэрээг хэрэгжүүлэх явцад холбогдох төрийн байгууллагуудад Санхүүгийн луйвар, авлигын эсрэг журмын талаар мэдээлэх;</li> <li>• Санхүүгийн луйвар, авлигын эсрэг журмыг хэрэгжүүлэх талаар олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх замаар төрийн байгууллагууд болон Монголын МСС-гийн хамтын ажиллагааг хангана.</li> </ul>	Төслийн хугацаанд	Нэмэлт зардал гарахгүй	Гэрээний менежер
Өндөр	10.4	Компактын хүрээнд хэрэгжүүлэх төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компани барилгын материал эсхүл тоног төхөөрөмжид шаардлагагүй өөрчлөлт оруулах	<ul style="list-style-type: none"> <li>• Монголын МСС нь барилгын материал, тоног төхөөрөмжийг өөрчлөх тохиолдолд зохих журмыг чанд баримтална;</li> <li>• МСК-ын хараат бус инженерийн хяналтын тогтолцоог нэвтрүүлнэ.</li> </ul>	Төслийн хугацаанд	Тухайн үйл ажиллагаанаас хамаарна	Гэрээний менежер
Өндөр	3.5.3.	Усны үнэ цэнэ, бодит өртөг шингэсэн тарифын талаарх олон нийтийн дадал хандлагыг өөрчлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага нь санхүүжилтийг зохисгүй ашиглах	<ul style="list-style-type: none"> <li>• Монголын МСС-гаас хяналт тавих журмыг боловсруулна;</li> <li>• Бие даасан хяналтын тогтолцоог бий болгох;</li> <li>• Олон нийтийн дадал хандлагыг өөрчлөх үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах.</li> </ul>	Төслийн хугацаанд	Нэмэлт зардал гарахгүй	Гэрээний менежер, Санхүүгийн баг

Цаашид Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хамаарч, эрсдэлийн үнэлгээний матриксыг тогтмол шинэчилж, дээрх жагсаалтад өөрчлөлт оруулан санхүүгийн луйвар, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоож ажиллах болно.